



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/243

Цсенбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 10 дугаар тогтоол, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн нэг аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Дөргөн нуурын эрэгт зохион байгуулагдах "Жангар-2023" зуны фестивалыг зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд 5,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2.Шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

